



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 20

Сүхбаатар

Төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнг  
уламжлах тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. 2015 оны 11 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд 238 иргэн оролцож 63 иргэн тэнцсэнээс 34 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 29 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгүүлэхээр 1,2 дугаар хавсралтаар баталж Төрийн албаны зөвлөлд уламжилсугай.

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 10 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 12 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь нэр дэвшүүлэхээр 3,4 дүгээр хавсралтаар баталж Төрийн албаны зөвлөлд уламжилсугай.

3. Төрийн албаны шалгалтыг зохион байгуулсан тухай илтгэх хуудас, хяналтын хуудас, шалгалтын дүн мэдээг боловсруулан хугацаанд нь Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Төрийн албаны мэргэшлийн шалгалтын салбар комиссын нарийн бичгийн дарга /Д.Ган-Отгон/-д даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА